



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг
Утас: 70-56-21-47, Факс: 70-56-21-12
E-mail: khentii@audit.gov.mn

2018.03.24 № 06/129
танай _____ -ны № _____ -г
Г _____ Г

ДАДАЛ СУМЫН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН
ЗАХИРАГЧ Б.ОЮУНБААТАР ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, мөн хуулийн 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8.9.2-д заасны дагуу Дадал сумын Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Дадал сумын Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Дадал сумын Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Дадал сумын Төсвийн ерөнхийлөн захирагч нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт,

түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.



ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.ЭРДЭНЭБААТАР

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ДАДАЛ СУМЫН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

Аудитын код: ХЭА-/2018/17/СТА-ТТЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар харилцана уу:

Цахим хуудас:

Хэнтий аймаг дахь төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Ч.Эрдэнэбаатар

Утас: 70562112 Цахим хаяг: Khentii @audit.gov.mn

Аудитын менежер Д.Оюунтуяа

Утас: 70562147 Цахим хаяг:

Аудитор Т.Алтанзул

Утас: 70562147 Цахим хаяг: altanzult@audit.gov.mn

Агуулга

2.1	Оршил	2
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	2
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	3
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	3
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	4
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	4
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	5
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	5
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл.....	5
2.9.1	Төлбөрийн акт тогтоосон алдаа, зөрчилтэй асуудал	6
2.9.2	Албан шаардлага өгсөн алдаа, зөрчилтэй асуудал	6
2.9.3	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал	6
2.9.4	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	6
2.10	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	6
2.11	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	6
2.12	Шилэн дансны мэдээлэл	7
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	8
2.14	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	8
3.	Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	9
3.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	9
3.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	9
3.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9
3.4	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9

2. Аудитын тайлан

2.1 Оршил

Дадал сумын Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг Дадал сумын Засаг дарга Б.Оюунбаатар таньд танилцуулж байна.

Энэхүү тайланд танай санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд үйлчлүүлэгчийн төсвийн зарцуулалт, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримтласан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

Дадал сумын ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт 6 төсвийн байгууллага, 3 орон нутгийн тусгай сан, сумын төрийн сан 1, байгаль хамгаалах сан 1, эмийн эргэлтийн сан 1 зэрэг нийт 12 санхүүгийн тайлан нэгтгэсэн байна.

Дадал сумын Эрүүл мэндийн төв, Ерөнхий боловсролын сургуулийн 2017 оны санхүүгийн тайланд “Өндөрхаан итгэл аудит” ХХК, Цэцэрлэг, Засаг даргын Тамгын газрын санхүүгийн тайланд аймаг дахь Төрийн аудитын газар аудитыг хийж, санал дүгнэлт гаргасан. Сумын Засаг даргын Тамгын газар, Эрүүл мэндийн төвийн санхүүгийн тайланд, Ерөнхий боловсролын сургууль, Цэцэрлэгийн санхүүгийн тайланд зөрчилгүй санал дүгнэлт өгсөн байна.

Аудитаар дүгнэлт гаргасан байгууллагуудаас дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

1. ЗДТГ-ын санхүүгийн тайланд төсвийн зарцуулалт, нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 4.14 сая төгрөг,
2. Хүүхдийн цэцэрлэгийн санхүүгийн тайланд төсвийн зарцуулалт, нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 4.12 сая төгрөг,
3. ЕБС-ийн санхүүгийн тайланд төсвийн зарцуулалттай холбоотой 0.83 сая төгрөг,
4. ЭМТ-ийн санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 4.4 сая төгрөг.

Нийт 13.49 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснийг засаж залруулах зөвлөмж хүргүүлсэн байна. /Дэлгэрэнгүй мэдээллийг тухайн байгууллагын аудитын тайлангаас харах/ Сумын ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын хүрээнд ИТХ, Соёлын төв, ОНХС, СХС, ЭЭС-ийн 2017 оны санхүүгийн тайланг түүвэрт хамруулан шалгалаа.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төсийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3, Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь заалтыг үндэслэн 15 дугаар зүйлийн 15.2.3-т заасан Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Дадал сумын Төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт,

нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Дадал сумын Төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан төрийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн ерөнхийлөн захирагч нь санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 3 дүгээр сарын 17-ноос 2018 оны 3 дүгээр сарын 22-ны хооронд хийж, аудитын тайланг 2018 оны 3 дугаар сарын 23-нд эцэслэн баталгаажуулж, сумын Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, аймаг Төрийн аудитын газрын аудитор Т.Алтанзул хариуцаж хэрэгжүүлэв.

Дадал сумын Төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дадал сумын Засаг даргын 2018 оны 3 дугаар сарын 01-ны өдрийн 1/49 тоот албан бичгээр Аймаг дахь Төрийн аудитын газарт Төсвийн тухай хуулиар тогтоосон хугацаанд ирүүлсэн байна.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Шилэн дансны тухай, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй байна.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитыг төлөвлөх, гүйцэтгэх, тайлагнах үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримтласан бодлого, стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

Аудитын үйл явц, үр дүнг Аудитын олон улсын стандартын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид Аудитын олон стандартад зааснаар үйлчлүүлэгч байгууллагын үйл ажиллагаа, гадаад дотоод орчны талаар төлөвлөсөн бодлого, журмын дагуу шаардлагатай гэж үзсэн хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Дадал сумын Засаг дарга " Санхүү, төсвийн төлөвлөлтийн үндэслэлийг сайжруулж, гүйцэтгэлийг хангах, нөөцийг оновчтой ашиглаж, хариуцлагын тогтолцоог уялдуулах, төрийн

сангийн шуурхай үйлчилгээг бий болгож төсөв санхүүгийн таатай орчин бүрдүүлэх замаар санхүүгийн эдийн засгийн үр ашигтай удирдлагар хангахад оршино " гэсэн эрхэм зорилгын дор Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна.

Дадал сумын Засаг дарга нь ИТХ, Тамгын газар, Цэцэрлэг, ЭМТ, ЕБС, Соёлын төв нийт 6 төсөвт байгууллага, 1 төрийн сан, 4 орон нутгийн тусгай сан, 1 эмийн эргэлтийн сантайгаар, 118 албан хаагчтайгаар ажиллаж байна.

Дадал сумын Төсвийн ерөнхийлөн захирагчийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, ТАБ-СТА-Б-2.1 маягтаар баталгаажуулсан болно.

Дадал сумын Төсвийн ерөнхийлөн захирагчийн удирдлага дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Дадал сумын Төсвийн Ерөнхийлөн захирагчийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэн аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Дадал сумын Төсвийн Ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан бэлтгэхэд төсвийн байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэдэг "Э-тайлан" програм хангамж ашиглажээ.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Дадал сумын ТЕЗ-ийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой уламжлалт болон хяналтын эрсдэлийг илрүүлэх, үнэлэх үе шатны ажлын талаар товч толилуулъя.

Аудитыг төлөвлөх үе шатанд байгууллага, түүний гадаад дотоод орчны талаарх цуглуулсан мэдээлэл ойлголтод үндэслэн эрсдлийн үнэлгээний горим хэрэгжүүлэн аудитын 6 эрсдэл тодорхойлон, тэдгээрийг ТБ-СТА-Б-2.2 маягтад нэгтгэж баримтжуулав.

Дээрх эрсдэлтэй асуудал тус бүрийг дахин нарийвчлан үнэлэхэд эрсдэл тохиолдох магадлалаас 5 асуудал тохиолдол боломж өндөр, 1 асуудал тохиолдох боломжтой, эрсдлийн нөлөөллөөс 4 асуудал их нөлөөтэй, 1 асуудал нөлөөтэй гэхдээ хянах боломжтой, дотоод

хяналтын үр дүнтэй байдлаас 5 асуудал сайжруулах шаардлагатай, 1 асуудал хангалттай бус гэсэн үр дүн гарлаа.

Эрсдэлийн ерөнхий үнэлгээг ТАБ-СТА-Б-4.3 маягтад нэгтгэн баримтжуулсан бөгөөд нийт эрсдэлийн үнэлгээний түвшин 18 буюу их эрсдэлтэй байна.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн эрсдэл дунд буюу зайлшгүй шалгах эрсдэлтэй 6 асуудлыг аудитын чиглэл тус бүрээр нэгтгэж, тэдгээрийг сорих – шалгах аудитын горим сорил, шалгуур үзүүлэлт, нотлох зүйл цуглуулах арга замыг холбогдох маягтаар баримтжуулан баталгаажуулсан болно.

2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Нийт орлогоос тооцоход улсын төсөвт төвлөрүүлдэг буюу байгууллагын үйл ажиллагаанд зарцуулдаггүй орлого нэмэгдэж тооцогдоно, нийт хөрөнгө болон цэвэр өмчийн дүн өндөр байгаа тул нийт зардлыг суурь үзүүлэлт болгон сонгох нь зохимжтой гэж үзлээ.

Дадал сумын ТЕЗ-ийн 2017 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 2171.8 сая төгрөг бөгөөд түүний 1 хувь 21.7 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тогтоох нь зохимжтой гэж үзлээ.

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, төлөвлөсөн ёсоор аудитын 5 чиглэлээр 6 эрсдэлтэй асуудалд 6 горим, сорил хэрэгжүүлж, түүний үр дүнг баримтжуулав. /ТАБ-СТА-В-3.1/

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэн тэдгээрийн гол үр дүн, нөхцөл байдлыг үнэлэхэд алдаа зөрчил илрээгүй болно. /ТАБ-СТА-В-4.1/

Харин аудитыг төлөвлөх шатанд эрсдэлтэй гэж тооцсон боловч, аудитын горим сорил хэрэгжүүлэх явцад алдаа зөрчилгүй нь тогтоогдсон асуудлыг ТАБ-СТА-В-4.2 маягтаар нэгтгэж, баримтжуулав.

2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

Дадал сумын Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитын хүрээнд түүвэрт хамруулан аудит хийсэн байгууллагуудаас сум хөгжүүлэх сан, орон нутгийн хөгжлийн сангийн санхүүгийн тайланд алдаа зөрчил илрээгүй. Сумын ИТХ-ын санхүүгийн тайланд хийсэн аудитаар:

-Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаараас давуулан гэрээгээр иргэний танхимын ажилтан авч ажиллуулан бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээ зардлаас 4.4 сая төгрөгийн цалингийн зардал гаргаж, батлагдсан төсвийг хэмнэлтгүй, үр ашиггүй зарцуулсан.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргахгүй байх талаар зөвлөмж өгөв.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргахгүй байх талаар зөвлөмж өгөв.

Сумын Соёлын төвийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар:

- Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаараас гэрээгээр 1 орон тоо хэтрүүлж, цалингийн сангаас 0.6 сая төгрөгийн зардал гаргаж, батлагдсан төсвийг хэмнэлтгүй, үр ашиггүй зарцуулсан.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргахгүй байх талаар зөвлөмж өгөв.

Сумын ЭЭсангийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар:

- Санхүүгийн тайланд тусгагдсан эзэн холбогдогч нь тодорхойгүй 2.86 сая төгрөгийн өглөгийг тооцоо нийлж үлдэгдлийг баталгаажуулаагүй.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргахгүй байх талаар зөвлөмж өгөв.

Дадал сумын ТЭЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн нэгж байгууллагуудад хийсэн аудитаар нийт 21.35 сая төгрөгийн алдаа зөрчил илэрч, үүнээс 4.72 сая төгрөгийн алдаа материаллаг, 16.63 сая төгрөгийн материаллаг бус залруулагдаагүй алдаа байна. Материаллаг бус алдаа нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын бичиг баримт мөрдөж ажиллаагүй, батлагдсан орон тооноос илүү хүн ажиллуулсан, засгийн газрын тогтоолыг мөрдөж ажиллаагүй, бараа материалыг орлогод аваагүй зэрэг зөрчлүүдтэй холбоотой байна. Эдгээр алдаа, зөрчлийг асуудлын бүртгэлд тусгаж, байгууллага бүрийн удирдлагад танилцуулан баталгаажуулсан болно.

2.9.1 Төлбөрийн акт тогтоосон алдаа, зөрчилтэй асуудал

Дадал сумын Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны санхүүгийн нэгтгэгдсэн тайланд хийсэн аудитаар төлбөрийн акт тогтоосон алдаа зөрчил илрээгүй.

2.9.2 Албан шаардлага өгсөн алдаа, зөрчилтэй асуудал

Дадал сумын Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны санхүүгийн нэгтгэгдсэн тайланд хийсэн аудитаар албан шаардлага хүргүүлэх алдаа зөрчил илрээгүй.

2.9.3 Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал

Дадал сумын Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны санхүүгийн нэгтгэгдсэн тайланд хийсэн аудитаар сахилгын шийтгэл ногдуулах зөрчилтэй асуудал гараагүй.

2.9.4 Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал

Хууль хяналтын байгууллагад шилжүүлэх асуудал гараагүй.

2.10 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татсан асуудал байхгүй.

2.11 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар батлагдсан төсвийн гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулж, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Дадал сумын ТЭЗ-ийн өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан урсгал зардалд 1497.9 сая төгрөгийн, хөрөнгийн зардалд 47.9 сая төгрөгийн төсөв баталсан байна. Батлагдсан төсөв, гүйцэтгэлийн талаарх мэдээллийг дор нэгтгэн харуулав.

№	Үзүүлэлт	/ сая төгрөгөөр/			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Зөрүү
1	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	1642.8	1611.5	-1.9%	31.3
1.1	Урсгал зардал	1497.9	1492.5	-0.36%	5.4
1.2	Хөрөнгийн зардал	48.0	48.0	-0.0%	0.0
1.3	Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл	96.9	71.0	-26.7%	25.9
2	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	1642.8	1598.2	-2.7%	44.6
2.1	Улсын төсвөөс санхүүжих	1159.5	1155.4	-0.3%	4.1
2.2	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	0	0	0	0
2.3	Орон нутгийн төсвөөс санхүүжих	351.0	350.8	-0.06%	0.2
2.4	Төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос	3.8	4.9	28.9%	43.6
2.5	Бусад эх үүсвэр	80.4	83.7	4.1%	3.3

Төсөвт зардлын гүйцэтгэл (1.9) хувь буурсан нь улс болон орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн жилийн эцсийн үлдэгдэл 0.36 хувь, хөрөнгийн зардал, эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл 26.7 хувь буурсантай холбоотой байна.

Батлагдсан төсвийн гүйцэтгэлийн талаарх мэдээллийг орлого, зардлын ангилал тус бүрээр аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд дэлгэрэнгүй харуулсан бөгөөд урсгал зардал 5.4 сая төгрөг буюу 0.36 хувиар хэмнэгдсэн байна.

Батлагдсан төсвийн гүйцэтгэлийн тайлангаас үзэхэд төсвийн гүйцэтгэлд анхаарал татахуйц их хэмжээний хэлбэлзэл алга байна.

2.12 Шилэн дансны мэдээлэл

Дадал сумын Төсвийн ерөнхийлөн захирагчийн хувьд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг "shilendans.gov.mn" цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байна.

Сумын төсвийн ерөнхийлөн захирагчийн Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, ил тод мэдээлсэн талаарх нотлох баримтыг ажлын баримт материалд хадгалав.

Аймаг дахь Төрийн аудитын газраас Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд 2017 оны эхний 10 сарын байдлаар нийцлийн аудит хийхэд мэдээллийг дутуу, хугацаа хоцроож байршуулсан зөрчилд албан шаардлага хүргүүлсэн ба мэдээллийг нөхөж байршуулж шаардлагыг хэрэгжүүлж ажилласан байна.

2.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар алдаа зөрчил илрээгүй бөгөөд өгсөн зөвлөмж байхгүй байна.

2.14 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Дадал сумын Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг Аудитын Олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Аудитын явцад нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн нэгж байгууллагад хийсэн аудитаар илэрсэн материаллаг, материаллаг бус залруулаагүй алдаа зөрчлийг материаллаг байдлын түвшинтэй харьцуулахад агуулга шинж чанарын хувьд аудитын санал дүгнэлтийг хязгаарлах үндэслэлгүй байна. Иймд Дадал сумын ТЕЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд зөрчилгүй санал өгөв. Энэ нь тайлангийн 2.9-д нэгтгэн тусгасан.

Дадал сумын Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж үзэж "Зөрчилгүй" санал дүгнэлт гаргалаа.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН: АУДИТОР



Ч.ЭРДЭНЭБААТАР Огноо:

Д.ОЮУНТУЯА

Огноо: 2018-3-25

Т.АЛТАНЗУЛ

Огноо: 2018.03.26

3. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

3.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

3.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

3.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

3.4 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан